

□
САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 5/11

Улаанбаатар хот

**"МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ,
ТҮҮНИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ"-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 91/110 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд тус тус даалгасугай.

**САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН**